

# Авлигын эсрэг тулах цэг бол төрийн алба

Монгол Улсын Их Сургууль  
Хууль зүйн Сургууль  
ЯЭЗ-н 4-р анги Г.Давааням

2011 он

## Сэдэв

1. Удиртгал
2. Судалгааны зорилго
3. Судалгааны ач холбогдол
4. Төрийн алба ба авлигын асуудал
  - 4.1. Төрийн албаны тогтолцоо
  - 4.2. Авлигын эсрэг тулах цэг ба төрийн алба
  - 4.3. Төрийн албан дахь авлигын төлөв байдал
  - 4.4. Төрийн албан дахь авлигын шалтгаан
5. Өнөөгийн авлигын эсрэг тогтолцоо
  - 5.1. Авлигтай тэмцэх газар
  - 5.2. Авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга хэрэгслэл
6. Дүгнэлт
7. Санал

## **Удиртгал**

Монгол улс 1990 онд ардчилсан хөгжлийн замыг сонгон нийгмийн бүх хүрээнд шинэтгэл хийж эхэлсэн бөгөөд энэ үеэс авлига гэх хорт үзэгдэл нийгэмд газар авч эхэлсэн билээ. Монгол улсад ардчилсан хувьсгал ялсанаас хойш авлига хэмээх хорт үзэгдэл газар авахад хэд хэдэн шалтгаан, нөхцөл яригддаг. 1990 оноос өмнөх Социалист нийгэмд иргэд бүгд адил өмч хөрөнгөгүй. Зөвхөн улсад ажил хийж, бүгд адил цалин авч, адил хувцас өмсч, адил хоол хүнс хэрэглэж байсан бөгөөд хүмүүст хувийн өмч хөрөнгийн талаар ямар ч ойлголт байхгүй байсан. Иймээс иргэд хэн хөдөлмөрлөсөн тэр хүн өмч хөрөнгө олж авах өрсөлдөөн бүхий чөлөөт зэх зээлийн эдийн засаг бүхий нийгэмд хөл тавьсанаар богино хугацаанд хөлжин хөрөнгөжих ил, далд бүхий л арга хэрэгслийг эрэлхийлэх болсон юм.

Мөн үүний зэрэгцээ Социалист нийгэмд бүхий л баялгыг төр өмчилж байсантай холбоотойгоор тухайн баялгыг хувьчлах асуудал мал, орон сууцын хувьчлалаар эхэлж одоог хүртэл шат дараатайгаар хувьчлал явагдсаар байгаа билээ. Үүний тод жишээ бол газар хувьчлал юм. Гэвч эдгээрийг эзэмших өрсөлдөөнд хэсэг бүлэг хүмүүс болон иргэд оролцохдоо авлигын арга хэрэгслийг сонгох нь элбэг байна. Нөгөө талаас төрийн алба тэр чигтээ улс төрийн намын эрхшээлд орчихсон байсан үе саяхан билээ. Сонгуульд ялсан нам өөрийн намын хүнийг төрийн албанд томилох нь энгийн үзэгдэл байсан. Гэвч энэ үзэгдэл өнөөг хүртэл ил, далд хэлбэрээр оршисоор байна.

## **Судалгааны зорилго**

Өнөөгийн төрийн албан дахь авлигын төлөв байдал, төрийн албаны үйлчилгээ түүнтэй холбоотой процедурын хэм хэмжээ, авлигын нөхцөл шалтгааныг судалж, Авлигтай тэмцэх газрын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагаа, арга хэрэгслэлд үнэлэлт өгөх замаар, Монгол Улсын авлигын эсрэг үйл ажиллагаанд үр нөлөө үзүүлэх арга хэрэгслэлийг эрэлхийлж, дэвшүүлэн тавихыг зорилоо.

## **Судалгааны ач холбогдол**

Авлига нь улс орны хөгжилд саад тотгор болж, эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн үр ашгийг бууруулан, ардчилал, шинэчлэлийн явцыг сааруулах хүчин зүйл болж байна. Манай орны хувьд 2006 онд шинэ Авлигтай эсрэг хууль баталж, “Авлигтай тэмцэх гарыг байгуулсан авлигын эсрэг арга хэмжээг шат дарааллан авч эхэлсэн. Энэ 5-н жилийн хугацаанд авлигтай тэмцэх асуудлын хүрээнд тодорхой хэмжээний дэвшил гарсан боловч, авлигын асуудал жил ирэх тусам газар аван, нийгэмд тархаж байгааг олон судалгаа харуулж байна. Иймд өнөөг хүртэл авлигын эсрэг хэржүүлж ирсэн арга хэрэгслэл дангаараа нөлөө багатай болох нь илт байгаа бөгөөд цаашид авлигын эсрэг юунд суурилан ямар арга замуудыг сонгон авч хэрэгжүүлэх нь зүйтэй болохыг санал болгох нь уг сэдвийн судалгааны ач холбогдолтой шууд холбоотой юм.

## **Төрийн алба авлигын асуудал**

### **1. Төрийн албаны тогтолцоо**

Монгол улс нь 2002 онд төрийн албаны тухай хууль баталсан юм. Уг хуульд тодорхойлсоноор “Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба”<sup>1</sup> гэнэ. “Төрийн албаны гол үүрэг эрх барьж буй засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх явдал мөн бөгөөд төрийн алба нь бодлого боловсруулдаггүй. Харин улс төрийн хүчинд зөвлөж, засгийн газрын бодлогыг хуулийн дагуу хэрэгжүүлдэг”<sup>2</sup> байгууллага бөгөөд “Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршидог”<sup>3</sup>

Өөрөөр хэлбэл төр оршин байгаагийн илрэл төрийн албан, түүний үйлчилгээ бөгөөд төр албаараа дамжуулан ард түмэнд үйлчилгээ үзүүлдэг. Иймд төрийн албаны тогтолцоо бол аливаа улс орны хувьд хамгийн чухал хэсэг нь байдаг бөгөөд улс орны хөгжилийн гол тулгуур нь болдог. Энэ үндсэн дээр төрийн албаны тогтолцоо нь шударга, ил тод, хурдан шуурхай, чадварлаг, мэргэшисэн, зохион байгуулалттай байх шаардлага зүй ёсоор тавигддаг. 2009 оноос эхэлсэн “Шударга, ил тод байдлын тайланд” өнөөгийн төрийн албаны тогтолцооны “шударга, ил тод байдал”-<sup>4</sup>ыг маш сул гэж дүгнэжээ. Харин авлигын эсрэг хууль тогтоомжийг “маш сайн” гэж үнэлсэн байна. Эндээс үзэхэд Монгол Улсын авлигын төрийн албаны шударга, ил тод байдал маш муу байгаа мөн хүнд суртал маш их байгаа нь авлига хэмээх үзэгдэл нийгэмд газар авч байгааг гол шалтгаан болж байна.

Хуульд заасны дагуу төрийн алба нь ил тод, шударга байх, ард түмэнд түргэн шуурхай үйлчлэх, иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх зэрэг зарчмыг баримтлах ёстой ба эдгээр зарчмын хэрэгжилт бодит байдал дээр маш сул байгаа нь иргэдийн төсөөллөөс харагдсаар байна.

### **2. Авлигын эсрэг тулах цэг бол төрийн алба**

Сүүлийн жилүүдэд нийгмийн бүхий л хүрээнд авлигын асуудал газар аваад байгаа бөгөөд тэр дундаас авлигад хамгийн их автагдсан газраар улс төрийн намууд тэргүүн ээлжинд нэрлэгдэж байна<sup>5</sup>. Энэ ч утгаараа төрийн албыг улс төржүүлэх явдал маш их байсан. Үүнийг таслан зогсоохын тулд 2008 онд Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, “улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч нь төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх, хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэнэ”<sup>6</sup> хэмээн зааж

<sup>1</sup> Төрийн албаны тухай хууль 3.1, 2002 он

<sup>2</sup> Жерми Поуп, Авилгалын эсрэг сурвалж бичиг, УБ., 2003, тал 163

<sup>3</sup> Төрийн албаны тухай хууль 3.2, 2002 он

<sup>4</sup> <http://report.globalintegrity.org/Mongolia/> 2009

<sup>5</sup> Транспарэнси интернэшнл Дэлхийн нийтийн авлигын хэмжүүр 2010.

<sup>6</sup> Төрийн албаны тухай хууль 10.6, 2002

өгсөн юм. Гэвч бодит байдал дээр төрийн албанд улс төрийн шинжтэй томилгоо оршисоор байгааг үгүйсгэх аргагүй. Үүнтэй холбогдуулан Доктор Ш.Цогтоо “Дээд газрын томилгоонд холбогдох 40 гаруй хуульд судалгаа хийж үзэхэд хоёрхон субъектийг, өөрөөр хэлбэл УИХ-н Тамгын газрын ЕНД, АТГ-ийн дарга хоёрыг л нам бус байна гэж онцлон заажээ. Бусад бүх дарга даамлын томилгоог “намаас түдгэлзэх” гэдэг нэрэн дор улс төрийн шалгуураар нь төрийн албанд томилсон байдаг”<sup>7</sup> гэж өгүүлжээ. Нөгөө талаас төрийн албаны ил тод, шударга, мэргэшисэн чадварлаг байх, хурдан шуурхай иргэдэд үйлчлэх шинжүүд сул байгаагаас төрийн алба нь өөрөө авлигад идэгдэх асуудал байна. Иймээс авлигатай тэмцэх эхлэлийн цэг нь улс төрийн сонгууль бус, иргэдийн эрх зүйн ухамсар бус, аж ахуй нэгж байгууллагын бизнесийн соёл бус, улс төрийн нам бус, төрийн алба юм. Үүнийг зөв шийдэл гэдгийг дараахи үндэслэлээр тайлбарлаж болно.

- ✓ Төрийн алба нь тухайн улс орны ард түмэнд чиглэсэн бүхий үйл ажиллагааг явуулдаг нийгмийн суурь тогтолцоо учир авлигын эсрэг тэмцэлийг ч гэсэн төрийн албыг гол чиглэл болгон төрийн албанаас эхлэх нь зүйн хэрэг.
- ✓ Төрийн албанд иргэд хэн нэгний дэмжлэгээр орох бус/тухайлбал улс төрийн томилолт/ өөрийн авьяас чадлаар шалгаран орж ажиллах бололцоо бүхий тогтолцоо нь тухайн иргэн танил талтай, хөрөнгө мөнгөтэй эсэхээс үл хамааран төрийн албанд орж төрийн албыг шударгаар гүйцэтгэх боломжтой.
- ✓ Төрийн алба нь босоо хэлбэрт тогтвортой тогтолцоо бөгөөд байнгын шинжтэй учир авлигатай тэмцэх ажлыг төрийн албанаас эхлэх нь үр дүнтэй юм. Төрийн албыг авлигаас ангижруулж чадсан тохиолдолд авлигын эсрэг хамгийн том хаалт болж чадна.
- ✓ Төрийн албанд “ улс төрийн намын нөлөө маш их”<sup>8</sup> байдаг нь нууц биш бөгөөд уг улс төрийн намуудтай холбоотой авлигын асуудал бүрийн эх үндсийг нь хянах нь бараг боломжгүй зүйл юм. Иймээс авлигын эсрэг хяналтыг албан тушаалын томилгоон дээр төвлөрүүлэн түүнийг шударга, ил тод явагдаж байгаа эсэхийг анхааран, дотоод хяналтын механизмыг боловсронгуй болгох нь маш чухалаар тавигдаж байна.

Түүнчлэн Доктор Ш.Цогтоо “төрийн алба гэдэг бол төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ”<sup>9</sup> гэж тодорхойлоод авлигын эсрэг тэмцэлд төрийн алба цөм нь байх ёстойг дараахь бүдүүвчээр илэрхийлжээ.


---

<sup>7</sup> Ш.Цогтоо, Нийтийн захиргаа, УБ., 2011 он тал 318-319

<sup>8</sup> Авлигын индекс 2009 судалгааны үр дүн, АТГ-аас явуулсан судалгаа

<sup>9</sup> Ш.Цогтоо, Нийтийн захиргаа, УБ., 2011 он, тал 326

## Бүдүүвч 1.



Мөн бусад авлигын эсрэг бусад орны туршлагыг судалж үзвэл улс орнуудын авлигыг багасгах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг гэвэл:<sup>10</sup>

- Авлигыг багасгах үйл ажиллагааг зөвхөн нэг байууллагын хүрээгээр хязгаарлахгүй нийгмийг бүхэлд нь татан оролцуулах гэсэн онцлог байна. Ж:нь Индонезид төрийн үйлчилгээний чанарт хяналт тавих омбудсмений алба бий болгож, мөн энэ чиглэлийн төрийн бус байгууллагуудыг бий болсон ба эдгээр байгууллагууд, мэдээллийн хэрэгслүүд нийгмийн хяналтыг бий болгон ажиллаж байгаа юм.
- Авлигтай тэмцэхийн тулд юуны өмнө уг ажилд хэрэглэдэг гол гол хэрэгслэлүүдээ цэвэр ариун болгоход анхаардаг байна. Ж:нь Хонг Конг тэмцэлийг цагдаагийн байгууллагаа авлиггүй болгохоос эхэлсэн байна. Индонез “шүүхийн комисс” хэмээх шүүгчийн үйл ажиллагаанд шинжилгээ үнэлгээ хийх байгууллагыг байгуулсан.

Дээр дурьдсанчилан Хонг Конг, Индонез зэрэг авлигын асуудалтай үр дүнтэй тэмцэж чадсан улс орны авлигын эсрэг тэмцэл нь төрийн албанаас эхэлж, төрийн албанд суурилж авлигыг таслан зогсоох системд суурилдаг юм.

### 3. Төрийн албан дахь авилгалын төлөв байдал

Төрийн албан дахь авлигын асуудлыг авч үзэхээс өмнө нь авилгал хэмээх ойлголтыг тодруулах нь зүйтэй болов уу? С.Нарангэрэл багш Авлига бол “Засаг төрийн төлөөлөгчийн чиг үүргийг гүйцэтгэж бус этгээд, түүнчлэн төрийн алба хашигсад аливаа хэлбэрээр эдийн ба эдийн бус баялаг, давуу талыг хууль бусаар олж авахын тулд өөрийн албан тушаалын байдлыг санаатай ашигласан, эдгээр этгээд худалдагдсан байдлаар илэрдэг улс төр буюу төрийн удирдлагын салбар дахь нийгэмд нэн аюултай үзэгдэл”<sup>11</sup> хэмээн тодорхойлжээ.

Энэ үзэгдлийг тодорхойлсон олон янзын тодорхойлолт байдагч “аливаа албан хаагч \төрийн болон хувийн хэвшлийн\ өөрт нь итгэж олгосон эрх хэмжээ

<sup>10</sup> А.Цанжид, Азийн орнуудын төрийн захиргааны шинэчлэл, туршлага, сургамж, 2011 он

<sup>11</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ.,2007 он, тал 5

буюу албан тушаалын байдлаа тухайн албаны эрх ашгын эсрэг хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашиглаж хийвэл зохих үүргээс татгалзах, эсхүл хийхийг хориглосон үйлдлийг хийх зүй бус үйлдлийг”<sup>12</sup> илэрхийлдэг. Өөрөө хэлбэл албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил гэж ойлгож болно.

Дээрхи дурьдсан “аливаа эрх зүйн зөрчил” хэмээх ойлголт өргөн ойлголт бөгөөд дотор нь нөгөө авлига гэж ойлгоод байгаа хээл хахууль, албан тушаалын гэмт хэргүүд багтаж бүрэлдхүүн хэсэг нь л болж байгааг харж болно. Өөрөөр хэлбэл авлигын зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байхаас гадна эрх зүйн зөрчлийн хэлбэрээр илэрнэ. Онол талаас бол авлигын үйл ажиллагаатай холбоотой гарч буй захиргааны болон сахилгын зөрчлүүд, харин практик дээр авлигын эсрэг төрийн бодлого, шийдвэр хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл эс үйлдэхүй л гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл авлигын гэмт хэргийн бүрэлдхүүнгүй боловч тодорхой санаа сэдэл, зорилгоор өөртөө болон танил талдаа, тал татаж ашиг хонжоо, давуу байдал олгох, олж авах хууль зөрчсөн, шудрага бус явдал юм.

Эндээс үзэхэд авлигын илрэх хэлбэр зөвхөн хээл хахууль өгөх, авахаар хязгаарлагдахгүй маш олон янз байх боломжтой. Тухайлбал: хээл хахууль, шан харамж, бэлэг, ах дүүсэх, найзархах, танил харах гэх зэргийг дурьдаж болно.

“Transparency international” байгууллагаас тогтмол гаргадаг Corruption Perception Index 2010 оны байдлаар Монгол Улсын авлигын түвшингээр 178 улсаас 116-д оруулсан байна.

Монгол Улс дахь авлигын төлөв байдлыг НҮБ-ын төрөлжсөн байгууллагын шинжээч, түүнчлэн иргэний нийгмийн байгууллага, МУ-ын Авлигатай тэмцэх газрын 1999-2009 онд гүйцэтгэсэн судалгаа, үнэлгээ, тайлан мэдээнд тулгуурлан дүгнэсэн байна. Үүнд:

Олон улсын “Transparency international” байгууллагын авлигын түвшиний үнэлгээгээр дэлхийн 178 улсаас Монгол Улс

❖ 1999 онд	\43-д\
❖ 2004 онд	\85-д байсан бол\
❖ 2006 онд	\99-д\
❖ 2008 онд	\102-д \
❖ 2009 онд	\120-д \
❖ 2010 онд	\116-д жагсаж байна\

Хэмжүүр 2010 судалгаанд оролцогчдоос улс дахь 11 гол салбар, байгууллагаас авлигад хамгийн их автсаныг нь тодруулсан. Тус жагсаалт нь “төрийн алба, боловсролын салбар, шүүх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, батлан хамгаалах, төрийн бус байгууллага, парламент, цагдаагийн

<sup>12</sup> Д.Зүмбэрэлхам, Авлигын гэмт явдал, УБ.,2011 он, тал 5

байгууллага, улс төрийн намууд, хувийн салбар, шашны байгууллагуудыг”<sup>13</sup> багтаасан байна.

Хэмжүүр 2010 судалгаа нь гааль, боловсрол, шүүх, газартай холбоотой үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, цагдаагийн байгууллага, бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ, татвар зэрэг үндсэн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын 77000 гаруй үйлчлүүлэгч, олон нийтээс эдгээр байгууллагуудад хандахдаа хээл хахууль өгсөн эсэхийг судалсан байна.

(Дээрхи 9-н байгууллагад хээл хахууль өгсөн байдал)<sup>14</sup>

		Улс/Газар нутаг
Өнгөрсөн 12 сарын хугацаанд тус есөн үйлчилгээг үзүүлж буй байгууллагад хээл хахууль өгсөн судалгаанд оролцогчид, хувиар	Бүлэг 1: 50.0% ба түүнээс дээш	Афганистан, Камбож, Камерун, Энэтхэг, Ирак, Либер, Нигер, Палестин, Сенегал, Сиерра Леон, Уганда.
	Бүлэг 2: 30.0%-49.9% ийн хооронд	Азербейжан, Болив, Эл Салвадор, Гана, Кени, Ливан, Лива, Мексик, Молдав, <b>Монгол</b> , Пакистан, Украин, Вьетнам, Замби.
	Бүлэг 3: 20.0%-29.9% ийн хооронд	Армен, Беларус, Босни Герцоговин , Чили, Колумб, Македон, Унгар, Папуа Шинэ Гвиней, Перу, Румын, ОХУ, Соломоны арлууд, Тайланд, Турк, Венесуэл.
	Бүлэг 4: 6.0-19.9 ийн хооронд	Аргентин, Австри, Болгар, Хятад, Чех, Фижи, Франц, Грек, Индонези, Итали, Япон, Косово, Латви, Люксембург, Польш, Филипин, Малайзи, Серб, Сингапур, Тайван, Вануату.
	Бүлэг 5: 6.0% ба түүнээс бага	Австрали, Бразил, Канад, Хорват, Дани, Финлянд, Гүрж, Герман, Хон-Конг, Исланд, Ирланд, Израиль, БНСУ, Голанд, Шинэ Зеланд, Норвеги, Португал, Словени, Испани, Швейцари, Их Британ, АНУ.

Хээл хахуультай холбоотой хүмүүсийн туршлагыг гүнзгийрүүлэн судлахын тулд Хэмжүүр 2010 судалгаанд яагаад хээл хахууль өгөх болсныг асууж тодруулсан. Судалгаанд оролцогчдын дөрөвний нэг нь “асуудлыг шийдвэрлэх хурдыг нэмэгдүүлэхийн тулд” болон “үйлчилгээг хүлээн авахын тулд” хээл хахууль өгөхөд хүрсэн” гэж хариулжээ .

<sup>13</sup> Транспарэнси интернэшнл Дэлхийн нийтийн авлигын хэмжүүр 2010.

<sup>14</sup> Транспарэнси интернэшнл Дэлхийн нийтийн авлигын хэмжүүр 2010.



(Хамгийн сүүлд хээл хахууль өгөх болсон шалтгаан, бүс нутгаар)<sup>15</sup>

	Ази Номхон далай	ЕХ+	Латин Америк	Ойрхи дорнод Хойд Африк	ШТТ Улсууд + Монгол	Хойд Америк	Сахар орчмын Африк	Баруун Балкан +Турк	Дүн
Захиргааны асуудлаас зайлсхийхийн тулд	12%	6%	10%	9%	12%	16%	67%	6%	44%
Асуудлыг шийдвэрлэх хурдыг нэмэгдүүлэх	28%	15%	44%	48%	28%	9%	20%	21%	22%
Үйлчилгээ авахын Тулд	35%	8%	34%	14%	21%	6%	11%	15%	17%
Мэдэхгүй	20%	59%	8%	20%	33%	59%	1%	53%	14%
Санахгүй байна	5%	12%	5%	10%	6%	10%	0%	5%	3%

Дээрх судалгаанаас харахад Монголын төрийн алба нь авлига, хээл хахууль ихээр авдаг ба төрийн албанд хүнд суртал маш их байгаа болох нь илт байна. Иймээс иргэдийн зүгээс “асуудлыг шийдвэрлэх хурдыг нэмэгдүүлэх”, “үйлчилгээ авах”-ын тулд ихэвчлэн хээл хахууль өгдөг байна.

Дээрх судалгааг бататгах мөн өөрийн Монгол Улсын төрийн албан дахь авлигын төлөв байдлыг нарийвчлан авч үзэх үүднээс Авилгалтай тэмцэх газраас хийсэн 2008 оны судалгааг авч үзье. Авилгалтай тэмцэх газрын США-аас “Авлигын ерөнхий төлөв байдлын тухай судалгаа”<sup>16</sup> явуулсан байна. Уг судалгаанд 21 аймаг, нийслэлийн 2990 иргэд, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 44.6% буюу 1333 нь иргэд, 43.4% нь төрийн албан хаагчид, 12.0 хувь буюу 360 нь бизнес эрхлэгчид оролцсон байна.

Иргэдийн өдөр тутмын амьдралтай холбоотой 14 төрийн үйлчилгээний сонгон авч эдгээр тохиолдол бүрт авлига, хүнд сурталтай холбоотой асуудал

<sup>15</sup> Транспарэнси интернэшнл Дэлхийн нийтийн авлигын хэмжүүр 2010.

<sup>16</sup> Авлигын ерөнхий төлөв байдал, “Авлигтай тэмцэх газар, Судалгаа шинжилгээний алба 2008 он

тулгарч байсан эсэхийг тодруулсан байна. Авлига, хүнд сурталтай холбоотой асуудал хамгийн их тохиолдлуудад газар өмчлөх, газрын зөвшөөрөл авах (заримдаа, ихэнх тохиолдолд, байнга гэж хариулсан судалгаанд эзлэх хувь-54.9%); их, дээд сургуульд элсэн орох, суралцах(46.8%); эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж авах (45.9); хүүхдээ ерөнхий боловсролын чанартай сургуульд оруулах, амжилттай төгсгөх (45.8%); хэрэгтэй байгаа ажилд орох, албан тушаал дэвших (45.6%) зэрэг тохиолдлууд орж байна.

“Та дээр дурдсан нөхцлүүдэд хээл хахууль өгсөн үү” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 57.2% тийм, 42.8% нь үгүй гэж хариулжээ. Иргэд хээл хахууль өгөх шалтгаан нь ерөнхийдөө гурван эх үүсвэртэй бөгөөд судалгаанд оролцогчдын 30.3% нь энэ тохиолдолд хээл хахуульгүйгээр асуудлаа шийдвэрлэх боломжгүй гэж урьдаас мэдэж байсан учраас, 24.0% нь албан тушаалтан хээл хахууль өгөхийг шаардаагүй боловч би өгсөн нь найдвартай гэж шийдсэн учраас, 8.7% нь албан тушаалтан надад санал болгосон, шаардсан эсвэл тийм байдалд оруулсан учраас хээл хахууль өгсөн гэж хариулжээ. Эндээс харахад авилга нь хэвшмэл үзэгдэл, тогтсон үнэ ханштай байдаг, нөгөө талаас иргэд өөрсдөө авлигыг бий болгодог гэж үзэж болохоор байна. Гэвч үүнийг зөвхөн иргэдтэй холбон тайлбарлаж болохгүй юм. Үүнийг доорхи хэсгээс харна уу?

Иргэдийн зүгээс төрийн албан хаагчдад хахууль өгснөөр төрийн албан хаагчдын асуудлыг шийдвэрлэх хурд, үр ашиг нэмэгдэж, иргэд өөрсөддөө ашигтай байдлаар асуудлаа шийдвэрлүүлж авч чаддаг байна. Ийнхүү хахууль өгснөөр албан тушаалтны үйл ажиллагаа (найрсаг байдал, асуудлыг шийдвэрлэх хурд, үр ашиг)-г 29.4% нь мэдэгдэхүйц эрс өөрчлөгдсөн, 33.9% нь зарим нэг талаараа өөрчлөгдсөн, 10.8% ер өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол нөгөө талаас хахууль өгсөн иргэдийн хувьд 24.2% нь асуудлыг шийдвэрлэх явц хурдассан, 14.0% нь асуудлыг миний талд ашигтайгаар шийдвэрлэсэн, 12.8% нь үүний үр дүнд тэд үүргийнхээ дагуу хийх зүйлээ хийхэд хүргэсэн, 10.6% нь зарим нэг хэцүү зүйлээс зайлсхийх боломж олгосон гэж үзсэн бол 9.7% хахууль өгснөөр ямар ч үр дүнд хүрээгүй гэж үзжээ.

Мөн төрийн байгууллага, албан тушаалтан хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй судалгаанд оролцогчидын 45.7% нь санал нийлж байна гэж хариулсан бол 34.2% нь зарим талаараа санал нийлж байна, 8.7% нь санал нийлэхгүй байна гэж хариулжээ.<sup>17</sup>

Эдгээр судалгаанаас харахад авлига өгсөнөөр ямар нэг байдлаар албан тушаалтаны асуудлыг шийдвэрлэх хурд өөрчдөгсөн гэж хариулсан хүн 60%-иас илүү байх бөгөөд эндээс төрийн албаны хүнд суртал хэр түвшинд байгаа нь илэрхий байгаа юм. Хээл хахууль өгөхгүй бол үүрэгт ажилдаа хайнга ханддаг, ажилаа хурдан шуурхай хийдэггүй гэж дүгнэж болох юм. Гэхдээ үүнийг зөвхөн албан тушаалтаны үйлчилгээний соёлтой холбон тайлбарлах нь өрөөсгөл болох бөгөөд энэ асуудлын талаар доор авч үзье

---

<sup>17</sup> Авлигын индекс 2009 судалгааны үр дүн, АТГ-аас явуулсан судалгаа

#### 4. Төрийн албан дахь авлигын шалтгаан нөхцөл

Авилгалаас урьдчилан сэргийлэхийн тулд иргэдийн авилгалын талаарх боловсролыг дээшлүүлэх нь чухал болох талаар зарим хүмүүс ярьдаг. Гэхдээ авилгалаас урьдчилан сэргийлэхийн тулд Монголд авилгал өгөх, авах нөхцөл шалтгаан нь юунд байгааг бүрэн тодорхойлоод, эдгээр нөхцлийг үгүй болгох арга хэмжээг авах нь чухал юм. Энэ арга хэмжээний хүрээнд дээрх нөхцөл шалтгааныг гаргуулахгүй байх, гарсан нөхцөлд хариуцлагын арга хэмжээ авах талаар хуулийн заалтуудыг холбогдох хуулиудад оруулж өгөх, төрийн албаны ажил, үйлчилгээг хүнд сурталгүй, төрийн албанд ажиллаж байгаа хувь хүний сонирхол, характераас үл хамаарах байдлаар зохион байгуулах, төр, засгийн нийт үйл ажиллагаа нээлттэй, ил тод, хэлбэрээр явагдах нөхцлийг бий болгох шаардлагатай байна.

Үүний тулд эхний ээлжинд бид авлига өгөх, авах нөхцөл шалтгааныг бүрэн гаргах шаардлагатай байна. “Манайд авилга өгөх, авах нөхцлийг бүрдүүлдэг олон хүчин зүйлс байдаг.”<sup>18</sup> Үүнд:

1. Иргэдийг авилга өгөхөөс аргагүй байдалд хүргэдэг дараахь нөхцлүүд байна.

- ✓ Төрийн албан тушаалтан нь иргэдээс ирүүлсэн аливаа хүсэлт, өргөдлийг шийдэж өгөхгүй уддаг байдал
- ✓ Төрийн албан хаагчид иргэдийг өөрөөсөө түлхэн, шаардлагагүй олон газраар явуулж чирэгдүүлдэг
- ✓ Хуулиар олгохоор заасан тусгай зөвшөөрлийг олгох ажлыг үе үе тодорхой бус шалтгаанаар зогсоодог, үндэслэл нь тодорхойгүйгээр олгохгүй түдгэлзүүлдэг.
- ✓ Аливаа бараа үйлчилгээний зохиомол хомсдол бий болгох эсвэл бий болсон хомсдолийг арилгахгүйгээр түүнийг авлигад ашиглах
- ✓ Хуулийн байгууллага хүнийг айлган сүрдүүлэх, дарамтлах

Дээрх авлигын шалтгаан нөхцөлүүдийг ажиглавал ихэвчлэн төрийн албан хаагчийн шударга бус байдал, хүнд суртал, тогтолцооны гажуудалтай холбогдон гардаг байна.

Түүнчлэн манай төрийн албаны эрх зүйн хүрээнд дараах асуудал тулгамдаж байна.<sup>19</sup>

1. Чиг үүргийг хэрэгжүүлэх “процедур”-ын зохицуулалт тодорхой бусаас төрийн үйлчилгээг “байх ёстой” зүйлийн хүрээнд бус “байгаа” нөхцөл байдалд тохируулан пратикаар тодорхойлох хандлага давамгайлж байна. Иймээс

- Албан тушаалтнууд хуулиар олгосон “бүрэн эрх” дээр “дахин эрх олгох” байдлыг бий бүрдүүлэх
- Ингэснээр түшмэл сэтгэлгээг нийтэд бүрдүүлэх
- Төрийн үйлчилгээ чирэгдэл ихтэй, удаан хугацаанд үзүүлэх бэрхшээлүүд тулгарч байна.
- Төрийн албанд албан тушаалтныг шалгаруулах ажиллагааны мэдээлэл хаалттай.
- Төрийн зарим үйлчилгээ техник ажиллагаа ихтэй, олон шат дамжлагатай байна.

<sup>18</sup> <http://khht1288.blogmn.net/>

<sup>19</sup> Ж.Сүхбаатар, Ж.Наранпүрэв, Төрийн албаны соёл, УБ., 2011 он

- Хялбар аргаар төрийн үйлчилгээг авах хууль бус сэдэл нийгэмд ноёрхох нөхцөл бүрдээд байна.

Энэ бүхнээс аваад үзэхэд төрийн албан хаагчийн хүнд суртал гаргадаг, хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэхгүй байгаа асуудал нь уг албан хаагчид ийм боломжийг олгож буй, авлига авах боломж олгож буй хэм хэмжээнд/процепурын хэм хэмжээ/ байна гэж дүгнэж болох юм. Өрөөр хэлбэл төрийн албанд бодит байдалд нийцэхгүй, хэрэгжихгүй хэм хэмжээ байх явдал эсхүл процессурын хэм хэмжээ огт байхгүй байгаа нь албан тушаалтанд авлига авах боломжийг олгож байна.

## **Өнөөгийн авлигын эсрэг тогтолцоо**

### **1. Авилгалтай тэмцэх газар**

Дэлхий дээрх авлигатай тэмцэх нэгэн сайн арга бол авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх дагнасан чиг үүрэгтэй бие даасан хараат бус байгууллага байгуулах явдал гэж олон улсын шинжээчид үздэг байна. Энэ асуудал нэлээд хэдэн орны практикаар нотлогдсон байдаг билээ. Дээрх үзэл санааны үндсэн дээр Монгол Улсад авлигын эсрэг бие даасан байгууллага болох Авлигатай тэмцэх газар нь 2006 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон “Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн” дагуу байгуулагдсан. Гэхдээ Авлигын эсрэг бие даасан байгууллага байгууллаа гээд авлигын асуудалтай үр дүнтэй тэмцэж чадна гэсэн үг биш юм. Гол нууц нь уг байгууллагын тогтвортой, авлигын эсрэг цогц арга хэмжээ авч явуулдагт оршидог болов уу?

Иймд өнөөгийн Монгол Улсын АТГ-ын авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг авч үзье.

### **2. Авилгын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга хэрэгслэл**

АТГ нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, уг хуульд заасан этгээдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага бөгөөд “УИХ-ын 2007 оны 1 дүгээр сарын 11-ны өдрийн 03 тоот тогтоолын дагуу урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэс, мөрдөн шалгах хэлтэс, тамгын хэлтэстэй”<sup>20</sup> үйл ажиллагаагаа явуулдаг.

#### **1. Урьдчилан сэргийлэх чиглэлээр<sup>21</sup>**

- ✓ Төрийн бүх шатны байгууллагад өгсөн зөвлөмжийн хэрэгжилттэй танилцаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх
- ✓ Авлига, хүнд суртлын эсрэг нээлттэй хэлэлцүүлгийг зохион явуулах
- ✓ Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар мэдээ, сурвалжлагыг олон нийтэд түгээх ажлыг зохион явуулах

<sup>20</sup> Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны товч танилцуулга, 2009 он

<sup>21</sup> Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны товч танилцуулга, 2009 он

- ✓ Гомдол мэдээлэл хүлээн авах, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар материал хэвлүүлэн тарааж олны хүртээл болгох
- ✓ Албан тушаалтнуудын, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулж явуулах
- ✓ Хуульд заасан албан тушаалтнуудад хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв гаргаж хэвшүүлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгийн тогтолцоог бий болгох
- ✓ Төрийн байгууллагуудын хүнд суртал, чирэгдлийг багасгах, мэдээллийг ил тод, нээлттэй болгох, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас төрийн бүх шатны байгууллагад Зөвлөмж хүргүүлж, заавар, зөвлөгөө өгөх

Улсын хэмжээнд 2007 онд хөрөнгө, орлогын мэдүүгээ бүртгүүлбэл зохих 41844 албан тушаалтны 97,4% нь буюу 39855, 2008 онд 47285 албан тушаалтнаас 98,9% нь буюу 46768, 2009 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтээр мэдүүлэг гаргавал зохих 53016 албан тушаалтны 99,93% буюу 52979 албан тушаалтан тус тус хуулийн хугацаанд мэдүүлгээ зохих байгууллага албан тушаалтанд бүртгүүлсэн байна. Ийнхүү жил бүр хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны тоо өссөн нь Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлт, Засгийн газар түүний бүтцийн байгууллагуудад бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбоотой, нөгөө талаар албан тушаалтнууд хөрөнгө, орлогоо мэдүүлэх үүргээ ухамсарлаж хуулийн хугацаанд мэдүүлж байгааг харуулж байгаа юм.

## 2. Соён гэгээрүүлэх чиглэлээр<sup>22</sup>

- ✓ Иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг тоймлон олон нийтэд хүргэх
- ✓ Авлигын эсрэг сургалт, семинарыг төрийн албан хаагчидыг хамруулан зохион байгуулах
- ✓ Авлигын эсрэг сургалт, семинарыг олон нийтийг хамруулан зохион байгуулах

## 3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах чиг үүргийн хүрээнд<sup>23</sup>

2010 оны байдлаар өмнөх жилийн үлдэгдэл 17 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан 466 нийт 483 гомдол, мэдээлэл хүлээн авсан байна. Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 494 үйлдэлтэй 136 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Эрүүгийн хэрэгт нийт 348 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсанаас Төрийн улс төрийн албан тушаалтан 22 буюу 6.0 хувь, Төрийн захиргааны албан хаагч 89 буюу 26.0 хувь, Төрийн тусгай албан хаагч 50 буюу 14.0 хувь, Төрийн үйлчилгээний албан хаагч 45 буюу 13.0 хувь, Энгийн буюу аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтан 136 буюу 39.0 хувь, Гадаадын иргэн 6 буюу 2.0 хувийг тус тус эзэлж байна.

Дээрхээс үзэхэд Авлигатай тэмцэх газар нь үйл ажиллагаа явуулж эхлээд 2 жил гаруй хугацаа өнгөрч байгаа боловч авлигын эсрэг тодорхой арга хэмжээг

<sup>22</sup> Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи мэдээлэл, 2010 он

<sup>23</sup> Мөрдөн шалгах хэлтсийн үйл ажиллагааны тайлан, 2010 он

авч чадаж буйг харуулж байна. АНУ-ын Азийн сангаас үндэсний хэмжээнд явуулсан авлигын түвшин тогтоох зургаа дахь удаагийн судалгааны дүнгээс үзэхэд “Хахууль нэхвэл Та яах вэ” гэсэн асуултад хахууль өгөхгүй гэж хариулсан хүний тоо өссөн ба “мөнгө байвал хахууль өгнө” гэж хэлж буй хүний тоо буурсан эерэг үзүүлэлт гарсан байна. “Анх судалгаанд оролцсон иргэдийн 45.7 хувь нь “мөнгө байвал хахууль өгнө” гэж хариулдаг байсан бол одоо энэ тоо 29.3 хувь болж буурчээ”<sup>24</sup>. Эндээс үзвэл нийгэм, олон нийтийн дунд авлигыг жигших уур амьсгал жигд бүрэлдэх хандлага буй болж байна.

Гэвч Олон улсын Транспэрэнси интернэйшнл байгууллагаас жил болгон гаргадаг авлигын индексээр Монгол Улсад сүүлийн хэдэн жилд тогтмол авилга өссөн гэсэн үзүүлэлттэй буюу жагсаалтын авлигад их автсан орнуудын хэсэгт байсаар байна.

Иймээс Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээг тэлж, иргэд рүү чиглэсэн бодлогыг дэс дараатай авч хэрэгжүүлэн, төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах, дотоод хяналтын үр дүнтэй механизмыг бий болгох, иргэд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлаа хянах онлайн хяналтын нээлттэй системийг бий болгон төрийн үйлчилгээний стандартыг боловсруулан хэрэглэж хэвшүүлэх, Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, улсын хэмжээнд авлигатай үр дүнтэй, үр нөлөөтэй тэмцэх төрийн нэгдсэн бодлого гаргах, төрийн албаны тогтолцоонд зохих шинэчлэлтийг хийх, төрийн албыг илүү ил тод, нээлттэй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

### **Дүгнэлт**

Монгол Улсад авилгалтай тэмцэх талаар шуурхай, далайцтай арга хэмжээ авч эхлэхгүй бол авлига газар авч нийгмийн бүх хүрээнд шударга бус цэцэглэж, авлигад бүрэн автах өдөр ойрхон байна. Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг олон нийт, төрийн соён гэгээрүүлэх, төрийн байгууллагуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хэлэлцүүлэг явуулах, хөрөнгө оруулгын мэдүүлгийн үйл ажиллагааг зохион явуулах, авлигын эсрэг хэрэгт хэрэг бүртгэл, мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулахаас хэтрэхгүй байна. Авлигатай тэмцэх газар байгуулагдсанаас хойш авлигын асуудал буурахгүй улам бүр ихсэж байгаагаас үзэхэд дээрх хэдэн арга нь авлигатай тэмцэхэд хангалтгүй болох нь тодорхой байна. Тиймээс дээрх авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэрэгслэл дээр авлигын эсрэг зохих шинэ арга хэрэгслийг авч хэрэгжүүлэх нь зүй ёсны зүйл юм. Мөн авлиг авах боломжийг бий болгосон тогтолцоо, эрх зүйн зохицуулалт байгаа тохиолдолд авлигын асуудал бууран гэж хэлэхэд учир дутагдалтай. Иймээс төрийн албаны үйлчилгээтэй холбогдуулан өөрчлөлтүүдийг хийх зайлшгүй шаардлагатай байна.

Судлаачийн зүгээс авлигатай тэмцэх хөшүүрэг бол төрийн албаны ажил, үйлчилгээ явуулах процедурт зохих шинэчлэлт хийх болон авлигын эсрэг шинэ арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Авилгалтай нийгмээрээ тэмцэх тэмцэлд амжилт авчрах хамгийн гол хичин зүйл нь төрийн албаны тогтолцоог эрүүлжүүлж, төрийн албаны шударга, ил тод байдлыг

---

<sup>24</sup> Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны товч танилцуулга, 2009 он

дээшлүүлж, төрийн албанд мэргэшисэн чадварлаг хүмүүсийг ажиллуулах явдал юм.

## **Санал**

Дээрх дүгнэлтэд үндэслэн судлаачийн зүгээс доорх саналыг дэвшүүлж байна.

- ✓ Төрийн албыг авьяас чадварт суурилсан тогтолцоонд шилжүүлэх/ Төрийн албанд орон тооны цомхотгол хийж мэргэшисэн чадварлаг хүмүүсийг авч ажиллуулах/

Төрийн албанд тэнцэхгүй хүмүүсийг төрийн албанаас шахаж, төрийн албанд авьяас чадвартай этгээдийг авах замаар төрийн албаны үйлчилгээг хурдан шуурхай, чанартай болгох. Мөн төрийн албаны шалгалтын дүнгийн жагсаалтыг нийтэд ил тод болгон, сул орон тоон дээр жагсаалтын дагуу ажил авах явдалыг нээлттэй болгон, хяналт тавих.

- ✓ Ард түмэнд үйлчлэхэд чиглэсэн төрийн албыг дэмжих. Өөрөөр хэлбэл төрийн албыг жинхэнэ утгаар нь иргэний үйлчилгээний алба болгон хөгжүүлэх.

Дээр дурьдсан судалгаануудаас харахад төрийн алба нь хүнд сурталд идэгдсэн нь илт байна. Энэ ч утгаар иргэд хурдан шуурхай үйлчилгээ авхын тулд төрийн албан хаагчидад хээл хахууль өгдөг байна. Төрийн албан хаагчидийн харилцааны соёлд анхаарад хандуулж, түргэн шуурхай, үйлчилгээг иргэдэд үзүүлэх тогтолцоог бий болгох. Ингэхийн тулд нарийн процедурын шинжтэй зохицуулалтуудыг шинээр батлах.

- ✓ Төрийн албаны ил тод, шударга байдлыг бий болгох болон хэвлэл мэдээлэл хараат байдлыг дэмжих

Дээрх судалгаануудаас харахад төрийн ил тод, шударга маш муу байна. Иймд энэ асуудал дээр анхаарч төрийн албанд орох, томилогдох асуудлыг нийтэд ил тод болгох нь чухал асуудал болоод байна. Аливаа нийгмийн 4 дахь засаглал хэмээн нэрлэгддэг хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалж, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг бий болгох.

- ✓ Төрийн албанд авахдаа төрийн албаны шалгалтанд тэнцсэнээс гадна өөрнийнх нь хувийн зан чанар, ёс зүйн төлөвшил ямар вэ? Гэдийг анхаарах хэрэгтэй

Энэ хүрээнд төрийн бүх шатны байгууллага бүрт ёс зүйг сахиулах, авилгалаас урьдчилан сэргийлэх асуудлыг эрхлэх, орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулах хэрэгтэй байна.

- ✓ Төрийн албан хаагчидын цалин хөлсийг нэмэгдүүлэн, амьдралын баталгааг сайжруулах дэс дараатай арга хэмжээ авах үндсэн дээр тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах.

Төрийн албан хаагчийн цалинг нэмсэнээр авлигын асуудал шууд багасана гэж хэлж болохгүй ч авлигын эсрэг тэмцэхэд нэгэн томоохон хөшүүрэг болох болно. Учир төрийн албан хаагчийн цалин бага байх нь тэдний зīgээс албан тушаалаа ашиглаж хувийн салбарынхнаас дутуугаа нөхөх шалтагийг бий болгодог. Тэдний хувьд төрд ажил хийгээд авч байгаа цалин нь биш, албан тушаал нь өөрөө їнэ ханштай болж амьдралаа залгуулах гол хэрэгсэл болж байна. Мөн төрийн албан хаагчийг цалинг нэмсэнээр хувийн салбарт ажиллаж буй чадварлаг боловсон хүчнийг төрийн албанд ажиллуулах эх үүсвэр бий болно.

- ✓ Төрийн албан хаагчийн буруу үйлдэл, алдаа нь санаатайгаар үйлдэхээс өөр нөхцлөөр үйлдэгдэхгүй байхаар ажлыг зохион байгуулахгүй байх. Өөрөөр хэлбэл дээрх алдаа гаргасан төрийн албан хаагчийг зөвхөн авилга авсанаас болсон гэж үзэх хэмжээнд үйл ажиллагааг зохион байгуулах/процедурын шинжтэй зохицуулалт/

Гаалийн ажилтан хилээр оруулж ирж байгаа барааг мэдэх боломжоор хангагдах буюу хориотой барааг оруулах, зөвшөөрөгдсөн бараанд татвар ноогдуулах ажил нь гаалийн ажилтан хэн байхаас үл хамааран хатуу нормчилогдсон, техник хэрэгслээр хангагдсан байх/ процедурын шинжтэй зохицуулалт /

- ✓ Захиргааны арга хэмжээ авах эрх бүхий албан тушаалтны ноогдуулах торгууль шийтгэвэрийн хэмжээ нь хатуу тогтоогдсон байх/ процедурын шинжтэй зохицуулалт /

Торгууль захиргааны арга хэмжээ авхуулсан субъект уг байцаагч, ажилтанаас ямар нэгэн байдлаар гуйх боломжгүйгээр мэдээг тэр дор нь дээш явуулах эсхүл цаашдын асуудлыг нь өөр хүн шийдэж байхаар зохицуулалт хийх/ процедурын шинжтэй зохицуулалт /

- ✓ Зөвшөөрөл өгөх, шийдвэр гаргах аливаа албан тушаалтанд дээрээс захиргаадаж зөвшөөрлийг олгуулах, шийдвэрийг гаргуулах асуудлыг хаах. / процедурын шинжтэй зохицуулалт /

Төрийн албаны аливаа үйл ажиллагаа, очер дараалал нь ил тод байх, тавигдах шаардлага нь тодорхой, шударга, нийтэд эрх тэгш үйлчлэх зарчимтай байлгах

- ✓ Төрийн үйлчилгээг боловсронгуй болгох

Төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх технологийн шийдлийг ашиглаж эхлэх, нэг цэгийн үйлчилгээг байгууллагын хэмжээнд бус салбарын хэмжээнд зохион байгуулдаг болгох, төрийн албан хаагчдийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох

*“Төрийн алба гэдэг нэрийг түмний үйлчилгээ, нийтийн үйлчилгээ” гэсэн ард түмэнд үйлчилэх ёстой жинхэнэ байр сууринд авчрах цаг нэгэнт болжээ.  
/МУИС-ХЗС, Доктор, Ш.Цогтоо/*



Эх сурвалж

Хууль эрх зүйн акт

1. Авлигын эсрэг хууль 2006 он
2. Төрийн албаны тухай хууль 2002 он

Ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл,

1. А.Цанжид, “Азийн орнуудын төрийн захиргааны шинэчлэл, туршлага, сургамж” 2011 он
2. Д.Зүмбэрэллхам, “Авлига гэмт явдал” УБ., 2011 он
3. Ж.Сүхбаатар, Ж.Наранпүрэв, “Төрийн албаны соёл” УБ., 2011 он
4. Жереми Поуп, “Авилгалын эсрэг сурвалж бичиг” УБ., 2003 он
5. С.Нарангэрэл, “Эрх зүйн эх толь бичиг” УБ., 2007 он
6. Ш.Цогтоо, “Нийтийн захиргаа” УБ., 2011 он

Эмхтгэл, судалгааны тайлан

7. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны товч танилцуулга, 2009 он
8. Авлигын ерөнхий төлөв байдал, Авлигтай тэмцэх газар, Судалгаа шинжилгээний алба, 2008 он
9. Авлигын индекс 2009 судалгаа, Авлигтай тэмцэх газар, Судалгаа шинжилгээний алба, 2009 он
10. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи мэдээлэл, 2010 он
11. Мөрдөн шалгах хэлтсийн үйл ажиллагааны тайлан, 2010 он
12. Транспарэнси интернэшнл Дэлхийн нийтийн авлигын хэмжүүр, 2010 он

Вэб сайт

1. <http://report.globalintegrity.org/Mongolia/> 2009
2. <http://khtt1288.blogmn.net/>